## “Абрахамын Бурхан ... Израилийн Бурхан”

# Израилийг Бурханы Эрх мэдэлт хүчээр сэргээсэн нь



Есүсийн мэндэлсэн газар болох Бурханы сонгосон Израйль

Аврагч Мессиаг сүнс зүгийн унталтаас болж танилгүй өнөөг хүртэл хүлээн суугаа хүмүүсийг сэрээх зорилгоор Доктор И Жэй руг болон Манмин Төв Сүмийн авралын зар түгээх багийнхан 2009 Олон Улсын Үндэсний Наадамд Израйльд очин оролцоцгоов. Тэд эдгэрэл адислалыг батлан гэрчилцгээхэд цулаанд оролцогчид гайхан баярлан, урлагийн тоглолтуудыг бишрэн үзэцгээж бас Есүс Христийг бидний аврагч гэдгийг нотлон тунхаглав.



Доктор И Жэй руг гадаадаас ирсэн олон чухал зочидтой гар барьж байгаа нь



‘Алтан Иерусалим’ хэмээх дуунд нийцүүлэн сэвүүрт бүжиг хийж байгаа нь




Доктор И Жэй руг гуай 26 төрлийн номууд нь олон хэл дээр орчуулагдан зарагдаж байгаа нь



Манмин ТВ-ын Захирал Ахлагч Жонни Ким үндэсний суваг болох 1-р сувгаар гарч байгаа нь




2009 оны Олон Улсын Үндэсний Наадам нь Реутерс болон АФП х гэх мэт хэвлэл мэдээлэлийнхнээр дэлхий дахинаа цацагдсан нь



Доктор И Жэй руг нь хүндэт захирлаар томилогдсон “Родное Израиль” хэмээх Израиль дахь анхны Христийн хэвлэл мэдээллийн төвийн нээлтийн үйл ажиллагаа



Хүзүүний маш хүнд өвчилөлтөөс ангижраад сэтгэл буй нэгэн эмэгтэй



19 жилийн дараа залбирал хүлээн аваад өвдөглөн суух болсон нэгэн оролцогч





30 настай Таня алхаж чадахгүй тахир дутуу байсан ч ангижирсан ба 53 настай Далиадам мөрний өвчнөөсөө ангижирсан нь




48 настай Медианг таягаа хаян Бурханд талархал өргөж байгаа нь



Израйлийн магтаал дуу, мөргөлийн баг



63 настай Мира тахир дутуу хүний тэргэн дээрээс босож чадах болсон байдал



Сургаал номлол анхааран сонсон суугаа нэгэн Еврей хүн



Өвчтэй хүүхдүүдтэйгээ хамт Доктор И Жэй руг залбирал хүртэж байгаа нь



Гепатит С/ Шарын С ангилал/ болон бусад олон өвчнөөсөө ангижирсан Мариса



Бурханы алдарыг магтан Англи, Франц, Орос, Еврей болон Лингала хэлүүдээр дуулж байгаа нь

### Мөргөлийн цаг

| Мөргөл | Цаг |
|---|---|
| Их мөргөл | Ням гариг 10: 30 |
| Үдээс хойших мөргөл | Ням гариг 13: 40 |
| 3-дахь өдрийн мөргөл | 3 дахь өдөр 18: 00 |
| 5-дахь өдрийн мөргөл | 5 дахь өдөр 22: 00 |
| Хүүхдийн мөргөл | ням гариг 10: 30 |
| Сурагч залуучуудын мөргөл | Хагас сайн өдөр 16: 30 |

### Залбирлын цаг

| Ангилал | Цаг | Удирдагч |
|---|---|---|
| Даниел үүрийн залбирал | Даваа- баасан 05: 00- 06: 00 | Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч) |
| Даниел өдрийн залбирал | Даваа- баасан 09: 00- 10: 00 | П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч) |
| Даниел оройн залбирал | Өдөр бүр 18: 30- 20: 00 | П. Батзориг (Чуулганы хариуцагч) |




**Хаяг:** Баянзүрх дүүрэг,
13-р хороолол 6-р хороо,
ой булан- 6 иргэний А.О.С
**Утас:** чуулганы- 5525-7637
чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.or.kr
www.manmintv.org

# Манмин Мэдээ

NO. 2 2009 оны 12 дугаар сар 20

# Доктор И Жэй руг, “Есүс Христ л цорын ганц Мессиа!”

## хэмээх сургаалт номлолоо 2009 оны Олон Улсын Үндэсний Урлагийн наадамд тунхагласан нь (2009 оны Израиль дахь Христийнхний Нэгдсэн Цуглаан) нийт 220 орнуудад цацагдсан



Доктор И Жэй руг гийн өвчтэй хүмүүст зориулан залбирсан залбирлын дараа бага насны тахир дутуу, үе мөчний өвчин, хараа муудсан байсан болон хорт хавдар гэх мэт өвчинтэй байсан хүмүүс өвчилөлтүүдээс эдгэрэн индэр дээр гарч ирж гэрчиллээ хуваалцацгаав.

2009 оны 9-р сарын 6-7-д Иерусалим хотын ОУКАТ-д (Олон Улсын Конференц Үйл Ажиллагааны Төв) Кристал Форумоос (Израилийн Пасторуудын Холбоо) зохион байгуулсан 2009 оны Олон Улсын Үндэсний Урлагийн наадам болж өнгөрөв.

Тус наадам нь “АГУУ ГАЙХАМШИГТ БУРХАН” хэмээн нэртэй зохион байгуулагдсан ба Израильчууд болон нийт 36 орны зочин гийчид хүрэлцэн ирцгээв. 9-р сарын 6-н болсон анхны цуглаан (Израиль цагаар)өдөр Доктор И Жэй руг “Бүхнийг Бүтээгч Бурхан” сэдэвт сургалаа айлдсан ба хоёр дахь өдөр нь “Есүс Яагаад Бидний Аврагч юм бэ?” хэмээх сэдэвт сургаал номлолоо айлдав. Сургаал номлолсны дараа И Жэй руг цугларалтанд хуран ирцээгээсэн өвчтэй хүмүүст зориулан эрүүл мэндийн адислал залбирлыг айлдахад эдгэрэл, авралыг хүртсэн хүмүүс индэр дээр гарч ирцгээн гэрчилэлээ хуваалцацгаав.

Энэхүү наадмын үйл ажиллагааг нийт 8 орны хэлээр сансрын 33 хиймэл дагуулын станцаар дамжуулан цацав. Үүнийг DayStar of USA, TBN-Russia, Enlace, CNL, Digital Congo, GCN, Miracle TV, and Heaven TV 7 гэх мэт зурагтын төвүүдээр 220 орнуудад дамжуулав.

## 2009 оны Хэргэм өргөмжлөлийн цуглаан

### Наян есөн хүн “Чин сэтгэлийн угаас сайн зүтгэлтэн болцгооё” хэмээх тангарагт урамшууллын цуглаанд оролцов.

9-р сарын 20-ны 3 цагт Пасторууд, Ахлагчид болон Халамжлагчид урамшуулсан өргөмжлөх цуглаан Ням гаригийн оройн үйл ажиллагаан дээр болов. Доктор И Жэй руг “Чин Үнэн Зүрх Сэтгэл” хэмээх сэдэвт сургаал номлол айлдав (Еврей 10:22). Тэрбээр сургаал номлолоо айлдахдаа Бурханы чин үнэнч зүтгэлтэн болох тангараг урамшуулалт хүлээн авсан хүмүүсийг: нэгт, Бурханы хүсэл зорилгыг дагах, хоёрт, ямар ч нөхцөл байдал тулгарсан шантрахгүй байх ба гуравт, Бурханыг сэтгэлийн чин угаас хайрлан хүндэтгэх хэрэгтэй хэмээн сурган заав.

Бурханы тааллыг хүлээн авах нийцтэй чин сэтгэлийн үнэн ч зүрх сэтгэлтэй болохыг уриалан дуудав. Энэ жил 13 пасторууд, 17 ахлагчид ба хүндэт ахлагч өргөмжлөлийг 2 ахлагч, 42 халамжилагч болон нийт 89 хүн өргөмжлөл хүлээн авцгаав.

Өргөмжлөлт үйл ажиллагааны дараа Сөүлийн Эмэгтэйчүүдийн Их Сургуулийн Захирал Асан Пастор Чунг Естер гуай талархлын үгсийг, Квангвооны Барилгын Их Сургуулийн Хууль Ёс Зүйн Магистерийн Сургуулийн эрхлэгч ахлагч Парг Сангёл сургамж хэлсэн ба үүний дараа Пастор И Сонг сук гуай бас талархлын үгс хэлэв. Үүний дараа “Халлелуяа” магт дууны багийнхан ая дууны мэндчилгээ өргөн барьж, өргөмжлөлийг гардуулж хаалтын залбирлаар тус үйл ажиллагаа өндөрлөв.

## Алчуурт цуглаан Тайландын Чианг Май мужын Чианг Рай хотод болов

Тайланд улсын Бангкае сүмийн 25 жилийн ой баяр ба (Тэргүүн Пастор Прасертоор удирдагдсан) Алчуурт залбирлын цуглаанд уригдсан Солонго пастор гэх Сонг чил Лее пастор удирдан нээв. Австрали, Сингапур, Энэтхэг болон Шри Ланка гэх зэрэг долоон орны пасторууд цугларан ирцгээж тус баярт оролцоцгоов.

Алчуурт залбирлын цуглаанд Намзам сүм дээр (Пастор Думрусын удирдагч) 14-нд, Чай Пуракан Манмин сүм дээр (Пастор Ворафоны удирдагч) 15-нд тус тус болж өнгөрөв. Цуглаан болгонд дээр Солонго Пастор Сунгчил Лее гуай “Бурханы Хүч Чадал” хэмээн диск бичлэгийг үзүүлэн Доктор Жэерок Леегийн сүмийн удирдлага болон түүний эдгэрэл анагаах хүч танилцуулж байв. Үүний дараа тэрбээр алчуурт залбирлыг (Үйлс 19:11, 12) үйлдэв. Маш олон хүмүүс үе мөчний өвчин, цусны өндөр даралт гэх мэт өвчилөлтүүдээс ангижиран эдгэрсэн ба Бурхандаа хандан залбирал алдрыг өргөцгөөв. Халамжилагч Жинхее Ким эгч болон “Кристал магт дууч” баг Тайланд хэл дээр ЭЗЭН БУРХАНЫГ алдаршуулан дуулсанд оролцогч олон таашаан хүлээн авав.

| Израйльд болсон наадамд(Фестивалийн) айлдсан сургаал номлол |

# Яагаад Есүс л Цорын Ганц Аврагч вэ?

“Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй гэв” (Үйлс 4:12)

Израиль бол Бурханы сонгосон ард түмэн. Тэрбээр Израиль улсыг сонгосон ба түүнийг одоо хүртэл Тэрбээр удирдан дагуулсаар байдаг (Дэд Хууль 4:31). Тэд Цорын Ганц Ариун Гэгээн Бурханд итгэдэг ба Түүний авралын тухай амласан амлалтыг нь биелэгдэхийг хүсэн хүлээцгээдэг. Дэлхийн маш олон хүмүүс одоогоос 2000 гаруй жилийн өмнө энэ дэлхий дээр мэндэлсэн Есүс Христийг тэдний Аврагч хэмээн итгэцгээдэг. Энэ талаар түр бодоцгооё.

Бурхан Адам Еваг бүтээгээд Адамд Тэрбээр, “сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэж болохгүй, хэрэв идвэл тэр дорхноо л үхэх болно” хэмээн хэлсэн байдаг (Эхлэл 2:17).

Гэвч Адам болон түүний эхнэр хоёр хорт могойн мэхлэлтэнд автагдан сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэцгээдэг. Энэ явдлаас Адам болоод хүн төрөлхтөн нүгэлд унасан ба үхлийг амсдаг.

Энд хэлэгдэж байгаа “үхэл” гэдэг нь зөвхөн бие махбодийн үхлийг хэлж байгаа бус тамд үхэл болон сүнсний үхлийг бас дурдан хэлж байгаа юм.

Есүс бидний Аврагч болох дөрвөн болзлыг хангасан тул Тэрбээр биднийг нүглийн хар сааднаас гэтэлгэн чөлөөлж чадсан юм.



Доктор И Жэй руг

Тэгвэл тэр болзлууд нь юу байсан юм бэ?

*Анхны болзол нь: Аврагч маань хүн байх ёстой* Учир нь үхэл нь нэг хүнээр ‘Адамаас’ ирсэн тул үхэгсдийн амилалт нь мөн нэг хүнээр иржээ (1 Коринт 15:21).

Тиймээс, Есүс энэ дэлхийд хүний бие махбодиор төрөн мэндэлж хүн төрөлхтөний бүх нүглийг ганц удаагийн золилтоор аврах ариун зорилготой ирэв (Еврей 7:27, 9:12).

*Хоёр дахъ болзол нь: Аврагч маань Адамын удамт байх ёсгүй* Адамын үр удам бүгд нүгэлт хүмүүс юм. Нүгэлт хүн бусдыг нүглээс нь гэтэлгэж чадахгүй. Мариа Жосефтэй хуримлахаас өмнө Есүс Ариун Сүнсээр төрсөн тул түүнийд уламжлан авсан гэм нүгэлгүй байв. Угтаа Есүс Онгон Мариагийн хэвлийг л түрхэн зуур хэрэглэсэн юм.

*Гурав дахъ болзол нь: Аврагч маань хүн төрөлхтөнийг аврах хүчтэй байх хэрэгтэй* Сүнслэг ертөнцийн хуулийн ухагдахуунаар нүгэлгүй байна гэдэг нь хүч юм.

Есүс Адамын удам биш учраас анхдагч нүгэлгүй хүн байв. Мөн түүнчлэн, Тэрбээр зөвхөн Бурханы сургаалаар амьдарч өсөж торнив. Тиймээс, Тэрбээр өөрийн зүгээс ямар ч гэм нүгэл үйлдээгүй юм (Еврей 7:26, 1 Петр 2:22).

*Дөрөв дэх болзол нь: Аврагч бидэнд хайртай байх ёстой* Есүс уг чанараараа ЭЦЭГБурхантай нэг учир Түүгээр хорвоо ертөнц бүтээгдэж, мөн Эзэмшигч юм.

Ямар ч гэм нүгэлгүй ариунхан Тэрбээр хэдий нүгэлт хүмүүс тийн ариун гайхамшигт өршөөлийг хүлээн авах зохисгүй байсан ч гэсэн Тэрбээр нүгэлт хүмүүсийн нүглийг өөртөө үүрэн загалмайд цовдлогдсон нь хэрхэн бидэнд хайртай болохыг илтгэж байна. Тэрбээр хайр, энэрэл байхгүй байсан бол хэзээ ч тийнхүү өөрийгөө золиослохгүй байх байсан.

Биднийг нүглийн хараалаас чөлөөлөхийн тулд (Ром 6:23), Есүс тэрхүү хараалыг өөртөө үүрэн модон загалмайнд эртний бичигдсэн хуулийн дагуу цовдлогддог (Галат 3:13).

Учир нь бүх махан биеийн амийн хувьд гэвэл, түүний цус нь амьтайгаа хамт байдаг (Левит 17:14, Еврей 9:22), тиймээс Есүс бидний нүглийн төлөөс болгон Өөрийн цусаа урсган цовдлуулсан юм. Муу ёрын сүнс хорон санаат хүмүүсийн бодол санааг эзэмдэн, тэднээр гэм нүгэлгүй байсан Есүсийг цовдолдог.

Гэвч Есүс ямар ч гэм нүгэлгүй байсан тул үхлийн хүчийг дийлэн дахин амилдаг. Тиймээс муу ёрын сүнс сүнслэг ертөнцийн хуулийг зөрчсөн. “Нүглийн төлөөс нь үхэл” хэмээн хэлсэн байтал Тэрбээр гэм нүгэлгүй хүнийг хороосон. Үүнээс болж Есүсийг аврагчаа хэмээн хүлээн зөвшөөрсөн хүмүүсийг үхлийн хүчнээс чөлөөлсөн юм (Ром 5:18).

Тиймээс, Их Эзэн Есүстэй нэгдэх болж, итгэлээр зөвтгөгдөн мөнхийн амьдралыг хүлээн авах юм. Үүнд загалмайнд агуулагдах авралын төлөвлөгөө биелэлээ олж байна. (1 Коринт 2:7).

Дээрх нийтлэл нь Доктор И Жэй руг ийн наадамын хоёр дахъ өдөр (2009 оны 9-р сарын 7-ны) сурган тунхагласан сургаалын хэсгээс авав.



Израилийн зүрх болох Иерусалумын Олон Улсын Конвенцын Төвд болсон “2009 оны Олон Улсын Үндэсний наадам”д Доктор И Жэй руг гуай 36 орны зочин гийчидэд зориулан сургаал номлолоо айлдав.




Доктор И Жэй руг гуай тус наадамд хүрэлцэн ирсэн дэлхийн олон орны Христэд итгэгчид Оросын Холбооны Улсаас ирсэн хүндэт зочидод нарт хандан Есүс Христ бидний Аврагч Мессиа хэмээх сургаалаа тунхаглан айлдав. Сургаал номлол нь Англи хэл рүү орчуулагдсан ба индэр дээр шууд Орос хэл рүү хөрвүүлэгдсэн ба хүрэлцэн ирэгсэд Еврей, Франц, Испани, Хятад болон Япон хэлүүдээр орчуулагдаж байв.

# Бурханы эрх мэдэлт хүч Иерусалимыг чичэргэн донсгов!

## Библийн үед тохиолдож байсан шиг гайхамшигт гайхамшигууд

Франк Вригт доктор АДХНМХ ерөнхийлөгч (АНУ дахъ Дэлхийн Христийнхний Нэвтрүүлг Мэдээллийн Холбоо) GCN-ны ерөнхийлөгч Нестор Коломбо,Сүнс Гэгээрлийн Гадаад дахъ Нийгэмлэгийн ерөнхийлөгч Михиал Могуйлис, Америкийн МҮС-ны (Мэдээлэл үйлчилгээний Сүлжээ) төлөөлөгч Дэн Воодинг, Евроазийн бүсийн НЛС-ийн дарга Пабло Баскуэз, Holy God ТВ-ийн захирал Герард Утаякумар ба бусад хүмүүс тус цуглаанг эхлэхийг тэсч ядан хүлээцгээв. 6:30-д тус наадмыг Кристал Форумын Ерөнхий Манажер Пастор Олег Хазин нээн үг хэлж түүний дараа Иерусалим хотын засгийн газрын Аялал Жуулчилал Гадаад Харилцааны Сайд Хилик Бар цуглааны талаар баяр хүргэн хүрэлцэн ирэгсдэд үг хэлэв. Израйлийн Аялал Жуулчилалын Хорооны Ерөнхий Захирал Ноаз Бар Нирийн, “Энэ сайхан цаг мөчид хуран цугларцгаан Иерусалимийн амгалан тайван байдлын төлөө залбирал үйлдэн сургаал айлдахаар ирсэн Доктор И Жэй ругд гүнээ талархаж байна.” гэж хэлсэн нь үнэхээр гайхалтай байв.

Нээлтийн үгсийн дараа Манмин сүмийн рлагийнхан үзэсгэлэнт гоёмсог сэвүүрт бүжиг бүжиглэн магтаал дууг дуулан 30 минутын урлагийн тоглолт явагдав.

Хөтлөгч Доктор И Жэй руг долоон жилийн турш өвчин зовлонд шаналан зовж байсны дараа Бурхантай уулзсан ба 30 жилийн турш номлогчийнхоо хувьд удирдлан зохион байгуулж ирсэн ажил үүргийг танилцуулж, дэлхийн маш олон орнуудад крусайд үйл ажиллагааг амжилттай явуулж байсанг онцлон дурдав.



Доктор И Жэй руг наадамд хуран цугларагсдад хандан эдгэрлийн адислалаа хайрласан ба тус үйл ажиллагааг дэлгэцээр үзэн суугаа үзэгч олонд хандан залбирал үйлдэв.

Доктор И Жэй руг индэр дээр гарч ирээд Израилийн Засгийн Газрынханд болон Иерусалим хотын засаг захиргаанд болон хүрэлцэн ирэгсэдэд хандан талархал илэрхийлэв. Түүний дараа тэрбээр “Бурхан Цорын Ганц Бүтээгч” болон “Агуу Гайхамшигт” хэмээх сургаал номлолоо айлдав. Хүрэлцэн ирэгсэд түүний сургаан айлдсан зүйлсийг анхааралтай сонсон сууцгаан ‘амен’ хэмээн хүлээн авч, алга ташицгааж байв.

Цуглааны хоёр дахъ өдөр Доктор И Жэй руг гуай “Есүс Христ яагаад цорын ганц Аврагч бэ?” хэмээн сэдэвт сургаалаа айлдсан ба тус наадамд ирсэн хүмүүсээс гадна цуглааныг ТВ, интернэтээр үзэж байсан хүмүүс хүртэл Доктор И Жэй руг ийг хэрхэн сургаал номлолоо ЭЗЭНий хүч дотор итгэлтэйгээр тунхаглаж байгааг гайхан биширцгээж байв. АДХНМХ ерөнхийлөгч Доктор Франк Бригт хэлэхдээ, “Энд өнөөдөр бид хуран цугларцгааж Амьд Бурханыг магтан дуулцгааж, гайхамшигт энэрэл хайрыг тунхагласан сайхан өдөр байна. Олон хүмүүс маш урт хугацааны турш өвчин зовлонд баригдан тарчилж байсан өвчнүүдээсээ ангижран сайжирч байгааг хараад би өөрийн эрхгүй баясан, баяр хөөрөө нуун сууж чадсангүй.” хэмээн сэтгэлээ илчлэв.

Эдгээр сургаал номлолуудаа айлдсаны дараа Доктор И Жэй руг гуай өвчтэй хүмүүст хандан залбирал үйлдэв. Асар түргэн хугацаанд тус танхим нь Ариун Сүнсний гал дөлөөр бялхаж гайхамшгууд үйлдэгдэж эхлэв. Маш олон хүмүүс итгэлийнхээ дагуу залбирлын хариугаа хүлээн авцгаав. Залбирал хийж дууссаны дараа индэр дээр өвчин зовлонгоосоо ангижирсан хүмүүс гарч ирцгээн гэрчилэлээ хуваалцацгаав. Хөлгүй байсан нэг нь хөлд орж, хараагүй нэг нь хараатай болцгоож тэд нүдний шилээ хаяцгаав. Залбирлыг хүлээн авах үед Ариун Сүнсний гал дөл тэдний бие махбодид мэдрэгдэн өвчин зовлонг нь устган ариусгаж байсанг тэд батлан гэрчилцгээв.

Пастор И Жэй руг ийн цуглааны нэгэн онцгой зүйл нь юу вэ гэвэл, ДХИЭХ (Дэлхийн Христэд Итгэгч Эмч нарын Холбоо)-ний гишүүд нь өвчтөнүүдийн өвчин тэмдэглэдэг ба залбирал хүртсэний дараа хэрхэн Бурханы гайхамшигаар хүмүүс эдгэрснийг ангаах ухааны үүднээс баталдаг.

63 настай Мира толгойн маш хүчтэй өвдөлттэй болон астматай (харшилт багтраа) байсан ба залбиралын дараа эдгэрч тэргэнцэрээсээ ч босов. 48 настай Хассе умайн хорт хавдраас эдгэрсэн байв. Мөн 52 настай Елбикиа үе мөчний өвчин болон нийт 11 төрлийн өвчин болон эмэгтэйчүүдийн өвчнөөс болж асар их зовиуртай байсан байв. Залбирал адислал хүлээн авахад ангижиран эдгэрсэн байв. 69 настай Елизабет чихрийн шижинг өвчинөөс болж нүдний хараа нь муудсан байсан тул 3 жилийн өмнөөс нүдний шил зүүдэг болсон байв. Тэрбээр адислал залбирал хүлээн авах үед түүний хараа нь сайжирсанд нүдний шилээ баярлан авч хаяв.

Дэлхийн нэр хүндтэй маш олон Христийн сэтгүүлч сурвалжлагч нар Есүс Христийн төрсөн газар Израильчуудад хандан Есүсийг цорын ганц Аврагч хэмээн тунхаглаж байхад үйлдэгдэж байгаа агуу гайхамшигуудыг хараад тэд өөрсдийн баясал хөөрөлөө нууж чадацгаасангүй. Оросын Холбооны Улсын Христийн Сүмийн Холбооны Ерөнхийлөгч болон ТВН-ын ерөнхийлөгч Игор Никитинтэй хийсэн ярилцлаган дээр тэрбээр, “Олон янзын улс үндэстэний төрийн болон бизнес эрхлэгч хүмүүс энд хуран цугларцгаан мөн Бурханы агуу гайхамшигийг гэрчлэн батлацгааж байгааг, урьд өмнө би харж үзээгүй гайхамшигт зүйлсийг ажиглан олж харлаа. Иерусалимд болсон энэхүү гайхамшигт зүйлсүүд нь эндхийн хүмүүст ч биш дэлхийн маш олон орны хүмүүсийн зүрх сэтгэлд гүн нэвчин орлоо.” хэмээн дурдан хэлэв.

Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм
235-3 Гуро-3донг, Гуро-гу, Сеүл, 152-848 Солонгос Улс
Утас: 82-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин

# Есүс Христ Дэлхий дахинаа тунхаглагдав

Тус төвийн дэргэд засан байрлуулсан буланд‘Сэр!Израиль’, ‘Загалмайн Сайн Мэдээ’, болон ‘Итгэлийн хэмжүүр’ хэмээх номуудыг зарж байв. Эдгээр номуудаас хамгийн их худалдагдсан ном нь ба “Эсэргүүцэх атьдрал ба дуулгаварт амьдрал” хэмээх ном нь хамгийн их худалдагдав. Мөн түүнчлэн, ‘Там’ ба ‘Эдгээч Ёхува’ хэмээх номууд бусдын анхааралыг ихэд татав.

## Ариун Сүнсний хүч нөлөө орон зайд цаг хугацаа үл хамааран үйлчилсэн нь

Израйльд болсон хоёр өдрийн турш үргэлжилсэн энэ фестивал нь нийт 220 орнуудад цацагдан нэвтрүүлэгдсэн ба эдгэрэл адислалыг зурагтаар хүлээн авсан хүмүүсийн гэрчлэл өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Бурханы ариун хүч чадал нь цаг хугацаа орон зай үл хамааран үйлчилсээр байна.

40 настай Норвано Казакстан улсаас тус цуглааныг СНЛ-ээр үзэж байв. Түүний хөлөө хөдөлгөж чадахгүй хэдэн долоо хоног болж байсан ба түүний хөл нь хөдөлж эхлэхийг мэдэв. Нэгэн танил нь тус наадамд оролцож байсан ба утсаар түүн рүү утасдан эдгэрлээ илчлэв.

Тус наадам нь Энэтхэг улсад Ахрулбакку ТВ болон Аврал ТВ хэмээх хэвлэл мэдээлэлийн сувгуудаар Тамил Наду болон Карнатака мужуудад цацагдан тараагдав. Мөн түүнчлэн Ченнай Манмин Сүм тус цуглаанд дэлгэцээр оролцов.



Үзэгч олон Бурханыг магтан дуулцгаасан нь

Номлогч Иосеф Хан гуай, Тус наадамд дэлгэцээр оролцсон хүмүүсийн талархсан гэрчлэлүүд өнөөг хүртэл бидэнд ирсээр байгаа ба тус цуглаан нь Хинди хэлээр хөрвүүлэгдсэн ба ЗЕЕ ТВ-гээр дахин цацагдсан юм. Нью Уоркт амьдран суудаг Рачел Каминер эдгэрлийг тус цуглааныг үзэж байгаадаа авсан ба бага байхаасаа өнөөг хүртэл зүүж байдаг байсан сонсголын аппаратаа авч хаяв. 55 настай Раксмиран, Непалын Манмин Номлолын Төв дээр бөөрний өвчнөөс эдгэрэв. 49 настай Мияа Гажурел дотоод цус алдалтаасаа бүрэн эдгэрсэн. 2 настай Санжи Тамажухее нь баруун гар болон хөлнийх нь үе мөчний өвчнөөсөө ангижиран эдгэрэв.

Гадаадын олон орнуудаас бас гадна Солонгост цаг хугацаа орон зай үл хамааран нөлөөлж эдгэрэлийг хүмүүс хүлээн авсаар байдаг. Сүмд үйлчилэгч Сухее Лим толгой өвдөх өвчнөөс эдгэрсэн. Сүмд үйлчилэгч Уонгок Лее арьсны өвчинөөсөө эдгэрсэн ба Халамжилагч Квангок Хванг өвдгөөр хатгах өвчнөөс бүрэн эдгэрэв. Тэд бүгд л эдгэрэл адислалыг хүртсэндээ Бурхандаа талархацгаав.

Наадмын үйл ажиллагааны үед Доктор И Жэй руг гуай халуун хуурай цаг агаартай, усны их дутагдалтай байсан тул Изральд бороо оруулахыг хүссэн залбирал үйлдэв. Изралийн Пастор Даниел Росен гуай бидэнд, “Наадмын үйл ажиллагаа дууссаны дараа Мягмар гаригт Изралийн хойд хэсэг болон төв хэсэгт бороо маш их орлоо” гэв. Израйльд 9 сард бороо орох тохиолдол маш ховор. Хамгийн гайхалтай нь долоо хоногийн дараа би Тел Авиваас Иерусалим руу явах үед бороо үерийн ус тогттол оров. Энэ нь яг л Доктор И Жэй руг гуайн хүсэн залбирсаны хариулт байв. Бороо орж байгаа нь Бурхан бидэнтэй хамт байсан гэдгийг гэрчилж байгаа юм.” хэмээн бичсэн байв.

Энэ жилийн наадмыг Кристал Форумаас зохион байгуулсан ба Израилийн пасторууд Доктор И Жэй руг ийг тус наадамд номлогчоор урьсан юм. Израилийн Христийн дагалдагч нар маш олон жилийн турш шахагдан хавчигдаж байсан ба хүчээ нэгтгэн Христийн үйл ажиллагааны арга хэмжээг тус хотод зохион байгуулсан нь гайхамшигтай явдал байв. Израилийн сүмүүд улам их хүчирхэгжин дахин сэргээгдэж байгаа нь Доктор И Жэй руг ийн Израиль руу хийсэн 12 удаагийн айлчлал болон нийт 777 өдрийг 2007 оны 7-р сарын 23-наас 2009 оны 9-р сарын 7-г хүртэл өнгөрүүлсэнтэй холбоотой юм.

Үүн дээр нэмж дурдахад Олон Улсын Конвенцын Төвд болсон энэхүү наадам нь Израилийн тус төвд болсон нилээд томоохон арга хэмжээнүүдийн нэг байв. Христийн арга хэмжээний, үйл ажиллагаа тус газар явагдсан нь бас нилээд онцгой тохиолдол юм.

## Хэвлэл мэдээлэлийнхэний анхааралыг маш их татав

Дэлхий дахинаа нэр хүнд бүхий хэвлэл мэдээлэл болох Реутер, АП ба АФП, Английн The Guardian болон Солонгосын Korea Herald хэмээх өдөр дутмын сонин болон ЭНС (ASSIST News Service), АНУ-ын Шашины Хэвлэл Мэдээ, Христийн Мэдээ, Христийн Сонин, Христийн сүмийн нэгдсэн сонин болон зэрэг гадаад дотоодын хэвлэл мэдээллийн газрынхан оролцоцгоов.

Христийн Телеграф мөн Украйн улсад нилээд алдартай сонин сэтгүүлд “Есүс Христийн загалмай сайн мэдээ нь Дэлхийн хязгаар Израиль хүртэл тунхаглагдав. Иерусалимын Пост хэмээх сонин дээр, “Сонсголгүй нэг нь сонсголтой болж, доглон нэг нь алхах болж, умайн хорт хавдраасаа эдгэрэн ангижирсан нэгэн эмэгтэй баярлан хөөрч байлаа. Мөн хүмүүс сүрьеэ өвчнөөс эдгэрцгээж байв.” гэж бичигдсэн байв.

Хоёр өдрийн турш явагдсан тус наадам нь нийт 220 орны 33 телевизийн төвүүдээр цацагдав. Наадам эхлэхээс өмнө Манмин ТВ-ийн захирал Ахлагч Жонни Ким 1-р сувгаар гарч Израилийн үндэсний телевизээр уг наадмыг танилцуулав.



33 Телевизийн төвүүдтэй холбогдон нийт дэлхийн 220 орнуудад ГХХС-гээр (Глобал Харилцаа Холбооны Сүлжээгээр) цацагдан түгээгдэв.